

**БАТЛАВ**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН  
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ

.....

**БАТЛАВ**

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:  
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ОНЦГОЙ БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ

Ж.ГАНБАТ

.....



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ХЭРЭГЖИХ “ЗАГИЙН УСНЫ ХООЛОЙН  
ГҮНИЙ УСНЫ ОРДООС НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ХҮРТЭЛ УС ТАТАХ ШУГАМ  
ХООЛОЙ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,  
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН  
БОУБХ-ИЙН ДАРГА

О.ГҮРРАГЧАА

2023 он

## Гарчиг

1	ОРШИЛ .....	1
2	Төслийн ТОВЧ танилцуулга.....	2
2.1	Төслийн зорилго, хүчин чадал.....	2
3	ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	4
3.1	Уур амьсгал .....	4
3.2	Геоморфологи .....	4
3.3	Ус зүй ба гидрогеологийн нөхцөл .....	4
3.4	Хөрс.....	5
3.5	Ургамлан бүрхэвч.....	5
3.6	Нийгэм, эдийн засаг .....	5
3.7	Төслийн талбайн байршил .....	6
4	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	6
4.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц.....	6
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	8
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	9
5.1	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө .....	12
5.1.1	<i>Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах ..12</i>	
5.1.2	<i>Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх.....12</i>	
5.1.3	<i>Бохирын цооногт септоник бодис хийж бактерийг устган, ялзруулж, саарал ус болсоны дараа гэрээт байгууллагад нийлүүлэх.....12</i>	
5.2	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө .....	12
5.2.1	<i>Ажилтны амрах хотхоны нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах 12</i>	
5.2.2	<i>Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх 12</i>	
5.2.3	<i>Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах .....</i>	<i>12</i>
5.2.4	<i>Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх 12</i>	
5.2.5	<i>Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр поошгинд цуглуулах.....</i>	<i>13</i>
5.2.6	<i>Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих .....</i>	<i>13</i>
5.3	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө 13	
5.3.1	<i>Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх.....</i>	<i>13</i>
5.3.2	<i>Ус цуглуулах 14 хүдгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах .....</i>	<i>13</i>
5.3.3	<i>Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах .....</i>	<i>13</i>
5.4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө....	13
5.4.1	<i>Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах.....</i>	<i>13</i>
5.5	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.....	13
5.5.1	<i>Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах .....</i>	<i>13</i>
5.5.2	<i>Үйл ажиллагаа явуулж буй газрын бүс нутгийн амьтдын хамгааллын талаар Мэргэжлийн судлаачаас зөвлөгөө авах, хамгаалах тал дээр ажиллах.....</i>	<i>14</i>
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	15
6.1.1	<i>Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....</i>	<i>15</i>
6.1.2	<i>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.....</i>	<i>16</i>
7	дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17

9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	18
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	19
11.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	20
12	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	22
13	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	23
14	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР .....	23

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт № 1. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл .....	3
Хүснэгт № 2. Эрсдэлийн үнэлгээний матриц .....	6
Хүснэгт № 3. Магадлалын үнэлгээний шалгуур .....	6
Хүснэгт № 4. Үр дагаварын үнэлгээний шалгуур .....	7
Хүснэгт № 5. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт .....	7
Хүснэгт № 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	9
Хүснэгт № 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө .....	15
Хүснэгт № 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	17
Хүснэгт № 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	18
Хүснэгт № 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	19
Хүснэгт № 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал .....	20
Хүснэгт № 12. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь .....	22
Хүснэгт № 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв .....	23

## **1 ОРШИЛ**

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд энэ тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Уг тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

Манай компани “Загийн усны хоолой”-н гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхай хүртэл ус татах шугам хоолой төслийн Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-ны 2022 оны 02-р сарын 28-ны өдрийн 13/1032 дугаар бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

БОНХУ-ний ажлын хамрах хүрээ нь ус татах шугам хоолойн барилга байгууламж барих үеийн болон ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Тус төлөвлөгөө Тавантолгой орд газрын Үйлдвэр, технологийн паркийн “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн үйл ажиллагаанд ашиглагдах үйлдвэрлэлийн зориулалтай усыг хангах “Загийн усны хоолойн гүний усны ордоос ус татах шугам хоолой” төсөлд хамаарахын хувьд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

## 2 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Төслийн зорилго, хүчин чадал

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд энэ тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Уг тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая.тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая.тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Загийн усны хоолойн газрын доорхи усыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нзрс баяжуулах үйлдвэр хүртэлх ус хангамжийн систем нь дараах барилга байгууламжаас бүрдэнэ:

1. Гүний худаг;
2. Ус цуглуулах шугам;
3. Ус цуглуулах усан сан;
4. Өргөлтийн насос станц;
5. Ус дамжуулах гол шугам;
6. 2x1500 м<sup>3</sup> усан сан
7. Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд
8. 2x1500 м<sup>3</sup> усан сангаас Нүүрс баяжуулах үйлдвэр хүртэлх салбар шугамууд

Тавантолгойн коксжих нүүрсний ордыг түшиглэн барихаар төлөвлөж буй нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийг Загийн усны хоолойн (I, II дэд) хэсэгт илрүүлэн тогтоож, усны ашиглалтын нөөц баялгийг үйлдвэрлэлийн С зэргээр (63.65 л/с)-ээр тооцсон бөгөөд тус ус дамжуулах шугамаар 5,499.31 м<sup>3</sup>/хоног ус дамжуулахаар төлөвлөсөн. Тавантолгойн нүүрсний уурхайн ус хангамжийн систем нь нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн шаардлагын улмаас 24 цаг тасралтгүй ажиллагаатай байна. Энэ байгууламж нь БНБД 40-02-16-д заасны дагуу ус хангамжийн I зэрэглэлд хамаарах учир 2 ажлын насостай байхад нөөц насос 1-ийг байрлуулах шаардлага тавигдаж байна. Иймд 1 нөөц насостой буюу нийт 3 насос суурилуулахаар техникийн ерөнхий шийдэл гаргав. Насосууд нь өөр дээрээ болон удирдлагын самбарт тусдаа давтамж хувиргагчаар тоногловол байвал цахилгаан эрчим хүчинд хэмнэлттэй байна.

Гүний худгуудын бүлэглэлт Загийн усны хоолойн I, II дэд хэсэгт байрлах нийт 14 ширхэг гүний худаг байгуулна. Гүний худгийн барилгын эргэн тойронд “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-д заасны дагуу энгийн болон онцгой хамгаалалтын бүс тогтоон заасан зайд хамгаалалтын хашаа төлөвлөнө. Хамгаалалтын төмөр хашаа нь гүний худгийн цооногийн координатаас 50 м-ийн зайд байна.

Өргөлтийн насос станцууд, шугам хоолойн хоорондын ажиллагааны гидравлик нөхцөлийг тогтвортой, найдвартай байлгах үүднээс насос станц бүрийн сорох талд усан сан төлөвлөнө. Усан сангийн хийц, материалыг хүйтэн бүсийн онцлог, технологийн шаардлагын үүднээс шийднэ. ӨНС-1-ийн өмнө 1х500м<sup>3</sup> эзэлхүүнтэй, ӨНС-2-ын өмнө 1х500м<sup>3</sup> эзэлхүүнтэй 12 м диаметр дугуй хэлбэртэй, өндөр нь 5.4 м газар доорх усан сан байрлана. Ус нөөцлөх усан сан нь ус дамжуулах гол шугамын төгсгөлд системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зориулалттайгаар байгуулагдана. Ус хангамжийн системийн ус дамжуулах хоолойд осол гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн технологийн шаардлагын дагуу технологийн усыг бууруулахгүйгээр хангана.

“Загийн усны хоолой”-н гүний худгуудаас усыг салбар шугам хоолойгоор цуглуулах усан санд нэгтгэн авч өргөлтийн насос станцуудын тусламжтайгаар далд шугам хоолойгоор шахаж уурхайн ойролцоо байрлах усан санд хүргэнэ. Уг усан сангаас уурхайн ус хэрэглээ болон кемп, захиргааны барилга, унд ахуйн усны хэрэглээгээ авах юм.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн Загийн усны хоолойн ус хангамжийн төслийн тус бүр 55 кВт хүчин чадалтай 2 өргөх насос станцыг тэжээх 2 ширхэг трансформаторын 35 кВ тал дээр SEL брэндийн SEL-311L шугамын гүйдлийн дифференциал хамгаалалтыг суурилуулна. Цогтцэций сумаас Манлай сум руу явсан 35кВ-ын ЦДАШ-наас огтолгоо хийж дэд өртөө байгуулахад 12 км урттай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаар төлөвлөсөн байна. Тус төслийн 35 кВ-ын ЦДАШ-д ЗТБ.35-04.18а маркийн төмөр бетон хийцтэй тулгуурыг суурилуулахаар сонгожээ.

Төслийн шугам хоолой, барилга байгууламжийн угсралтын ажлыг 6 компани түншлэл хэлбэрээр гүйцэтгэнэ. Мэдээллийг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт № 1. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл*

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
Эс Энд ЭйТрэйд ХХК	Барилга угсралт	Улаанбаатар хот, Чингэлтэй, 1-р хороо, 8, 1 тоот
ЧММ ХХК	Барилга угсралт, засвар	Улаанбаатар хот, Хан-Уул, 3-р хороо, ажилчны, ЧММ ХХК-ийн байр
Набсан ХХК	Гадаад худалдаа, Барилга угсралт	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, ЧД, 4-р хороо дипломат 95-р байр 122-11 тоот
Тэргүүн Инвест ХХК	Гадаад худалдаа, Барилга угсралт	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол, 121а байр, 701 тоот
Сан ХХК	Барилга, цахилгаан, сантехник угсралтын ажил	Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрчний гудамж-90
Бридж Констракшн ХХК	Барилга угсралт	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Бридж Плаза



### 3 ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

#### 3.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь  $-14.8^{\circ}\text{C}$  хүрдэг, үнэмлэхүй их температур нь  $41.3^{\circ}\text{C}$  хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор  $8.0^{\circ}\text{C}$ .

Жилийн дундаж агаарын температур нь  $0.9^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн I сарын дундаж температур  $-14.6^{\circ}\text{C}$  бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур  $23.1^{\circ}\text{C}$  байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

#### 3.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

#### 3.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Талбайн хэмжээнд байнгын урсгал ус байхгүй. Бороо их орсон үед хуурай сайр жалга нь түр зуурын урсгал устай болох ба уулс хоорондын хөндий, хотгоруудад түр зуурын давсархаг нуурууд үүсдэг. Уурхайн үерийн шуудуу, хөрсний овоолго, дэвсэлт хийж байгуулсан зам зэрэг антропоген байгууламжуудад хаагдан түр зуурын тогтонги ус үүсч бий болдог ба тус усыг уурхайн тоосыг бууруулахад өргөн хэрэглэж байна. Колдышева. Р.Я. нарын зохиосон гидрогеологийн 1:500 000 зурагт Улаан нуур хэмээх тойрмыг “шорвог устай нуур” гэж тэмдэглэсэн байдаг. Уг тойромд сүүлийн олон жилийн туршид ус хуримтлагдаагүй байсаар 2018 оны зуны дараалласан их аадар борооны үр дүнд эргээсээ хальж дүүрсэн байна. Уурхайчид Улаан нуурын ус хальж каррьер руу орж ирэх вий гэсэн айдас тухайн үед байсан. Гэсэн ч энэхүү их хэмжээний ус 2019 оны зуны халуунаар ууршиж алга болсон.

Таван толгойн ордын орчимд байнгын урсгал болоод тогтмол ус байхгүй учраас гадаргын ус хуурай сайрууд болон Улаан нуурт түр хугацаанд үүсч байсан, эс үүсч байсан, хуурай сайруудаар үерийн ус урсаж юмуу, ус тогтож байсан эсэх, хэрэв ус урсаж юмуу тогтож байсан бол хэдий хэмжээний урсац, тогтмол ус үүсч байсан талаар албан ёсны ямар нэгэн мэдээ сэлт байхгүй байна (2009).

Тавантолгой Цанхийн баруун болон Цанхийн зүүн уурхай тэлж Бортээгийн талбайд хөрсний овоолго байгуулж эхэлсэн цагаас Улаан нуур руу зүүн талаас цутгадаг урсгал



хаагдах болсон байна. Ингэснээр 2018 оны зун улаан нуурын зүүн талд Улаан нуурын Бортээгийн отвал руу хүрдэг замын баруун талаар хангай газрын жижиг гол руугаа адил морфологитой урсгал ус үүсч улирлын турш байсан.

### 3.4 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

### 3.5 Ургамлан бүрхэвч

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хамаарах бөгөөд цав толгод уулс зонхилсон, харьцангуй өндөр (д.т.д 1400-1600м) нутаг юм. Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Иран Тураны Их мужийн Төв Азийн хээр цөлийн дэд мужийн Монголын хээр цөлийн хошууны Умард говийн цөлөрхөг хээрийн дэд хошууны Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна.

### 3.6 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2019 оны байдлаар нийт 113,349 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 8119 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

*Хүснэгт 1. 2021 оны хүн амын тоо*

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	72943	8599
Эрэгтэй	36881	4390
Эмэгтэй	36062	4209
Өрхийн тоо	23164	2643

Өмнөговь аймаг нь 2021 оны байдлаар 2513.8 мян тоо толгой мал тоологдсоноос Цогтцэций суманд 151.65 мян толгой мал тоологдсон байна.

*Хүснэгт 2. 2021 оны мал тоо*


Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2513.81	102.02	31.28	160.58	626.71	1593.2
Цогтцэций	151.65	10.57	2.18	3.52	53.73	81.66

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая.тн нүүрс олборлон экспортлож байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Мөн 2019 оноос Улаанбаатар хотыг утаагүй болгох ажлын хүрээнд 100 орчим хүнд даацын машинууд нүүрс тээвэрлэж, зам дагуу нутагладаг малчдын бэлчээрийг талхалж, тоосжилт үүсгэн, өдөр шөнөгүй тээвэр хийж байна. Мөн замын дагуух худаг усыг бохирдуулах, хог хаягдал үүсгэх, зогссон газраа засвар үйлчилгээ хийж тос тосолгооны материалын асгаралтыг үүсгэж нь байгаль орчинд маш их нөлөө үзүүлж байна.

### 3.7 Төслийн талбайн байршил

“Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НБҮ хүртэл ус татах шугам хоолой” төсөл нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 425 км, аймгийн төв Даланзадгадаас зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн хойш зүгт 65 км хүртэл зайд эхлэлийн цэг орших ба эхлэлийн цэгээс шулуунаар үргэлжлэн сумын төвөөс зүүн ба зүүн урагш 6 км зайд байрлах нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд хүрнэ.



Зураг № 1. "Загийн усны хоолой" төслийн байршлийн зураг

## 4 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

### 4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон

Хүснэгт № 2. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 3. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)

III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 4. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Хүснэгт № 5. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	ҮЗ <sup>2</sup>		Хариу арга хэмжээ
				ҮД <sup>1</sup>	ЭЗ <sup>2</sup>	
Кемп, барилгын ажил	Хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол	4	1	II	Хог хаягдлын ангилан ялгалт
			3	1	I	Хогийн түр цэг байгуулах, ариутгал халдваргүйжүүлэлт
			3	2	II	Гэрээ байгуулах, хатуу хог хаягдлыг зөвшөөрөлтэй цэгт зайлуулах
			3	2	II	Бохир усыг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх
Машин техникийн хөдөлгөөн	Бэлчээрийн доройтол, салаа зам	Хөрсний эвдрэл	4	3	III	Зам талбайг усаар чийглэх
			4	3	III	Хөдөлгөөний хурдын хязгаарлалт, маршрутын замаар зорчуулах
	Дуу чимээний түвшин нэмэгдэх	Амьдрах орчин	4	3	III	Нөлөөллийн бүсийн айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, ажлын байраар хангах, техникийн дэмжлэг үзүүлэх

<sup>1</sup> Үр дагавар: 1

<sup>2</sup> Эрсдэлийн зэрэглэл: I – Бага, II – Дунд, III – Өндөр, IV – Маш өндөр

Ус хангамж /ахуй/			4	2	II	Усны хэрэглээний хяналт
Ус хангамж /барилга/	Ус ашиглах	Усны эх үүсвэр багасна	4	3	III	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр гэх мэт
Барилга байгууламж, шугам хоолой	Зөвшөөрөлгүй ашиглах	ТТАМ нөөц, хууль зөрчих	4	4	V	Зөвшөөрөлтэй ААН-тэй гэрээ байгуулж ашиглах
	Нүх, ухаш үүсэх	Мал амьтан унах	3	2	III	ХАБ-н арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх
Ажилчдын кемп	Зөвшөөрөлгүй ашиглах	Хөрс, газрын гадарга доройтох	4	3	IV	Орон нутгаас түр ашиглах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах

#### 4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянаж байх явдал юм.

“Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НБҮ хүртэл ус татах шугам хоолой” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх;
- Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх;
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах;
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах;
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх;
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох;
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах

## 5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал ₮	Эрх зүйн баримт бичиг
<b>5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>							
5.1.1	Төсөл хэрэгжүүлэх үед тоосжилт үүсэх (Машин механизмын хөдөлгөөн, хөрсний элэгдэл, эвдрэл)	Зам талбайг усалж тоосжилтыг дарах	Шороон зам, барилгын ажлын талбай	-	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016
5.1.2	Дуу чимээний түвшин нэмэгдэх	Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх	Төслийн талбайд	Жилд 2 удаа	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	MNS 4599:2003 Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд
5.1.3	Түр ашиглах Ариун Цэврийн байгууламжийн үйл ажиллагаа	Бохирын цооногт FM болон септоник бодис хийж бактерийг устган, ялзруулж, саарал ус болсоны дараа зөөвөрлөж асгаж байх	Төслийн талбай, түүний эргэн тойрон	1 ш	Төслийн хугацаанд	11,400,000	MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
<b>5.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>							
5.2.1	Нянгийн бохирдлоор хөрсний бохирдол үүсэх	Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах /хлорын шохой - Эколо/	Кемпүүдийн нүхэн жорлонд	3 ш	Төслийн хугацаанд	1,500,000	MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
5.2.2	Хүний хөдөлгөөнөөр хөрс талхлагдах	Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх	Кемп орчим	3 ш	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
5.2.3	Зөвшөөрөлгүй хайрга, дайрга олборлож ашиглах	Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах	Туслан гүйцэтгэгч компаниуд	-	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль



Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал ₮	Эрх зүйн баримт бичиг
5.2.4	Өнгөн хөрсийг буруу технологиор хадгалсанаар хөрсний бүтцэд өөрчлөлт орох, чийгээ алдах. Ургамал хатах, улмаар үхэх.	Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх.	Төслийн талбай	-	Төслийн хугацаанд	5,580,000	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимтэй хөрс хуулалт, хадгалалт
5.2.5	Машин техникийн тос масло, дизель түлш асгарч гоожисноос хөрс бохирдох	Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр поошгинд цуглуулах	Машины зогсоол	3 ш	Төслийн хугацаанд	Үйл ажиллаг ааны зардал	MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
5.2.6	Зөвшөөрөлгүй газар ашиглах, хог хаягдлын гэрээ байгуулахгүй үйл ажиллагаа явуулах	Ажилчдын кемп байгуулахын өмнө сумаас зөвшөөрөл авах, ЭТТ ХК-аас хяналт тавьж ажиллах	Туслан гүйцэтгэгч компаниуд	-	Төсөл эхлэх үед	Үйл ажиллаг ааны зардал	Хог хаягдлын тухай хууль, Газрын тухай хууль
5.2.7	Олон салаа зам гаргаж бэлчээрийг доройтуулах	Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих	Сум-төслийн талбай хоорондын шороон зам	91 км	Төсөл эхлэх үед	Үйл ажиллаг ааны зардал	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
<b>5.3 Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>							
5.3.1	Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах.	“Шингэн хаягдал халих, бохир ус алдах зэрэг гүний болон гадаргын усыг бохирдуулахаас сэргийлэх	Төслийн талбай	1 ш	Төслийн үед	5,000,000	MNS 4047:1988 Байгаль орчны хамгаалал, усан мандал. Газрын доорхи усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
5.3.2	Ашиглалтын явцад гүний усны түвшин буурах	Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	Гүний худаг	14 ш	Төсөл эхлэх үед	11,200,000	Усны тухай хууль

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж,	Нийт зардал ₮	Эрх зүйн баримт бичиг
5.3.3	Нутгийн иргэдийн ашигладаг гүний худгууд ба гар худгуудын усны түвшин буурч, ундарга багасах	Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах	Нөлөөллийн бүс	2 ш	Төслийн хугацаанд	800,000	Усны тухай хууль
<b>5.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>							
5.4.1	Ургамлын нөмрөг устгах, дарагдах, нөлөөлөлд өртөж доройтох	Үйл ажиллагаа дууссаны дараа биологийн нөхөн сэргээлт хийх зорилгоор тухайн талбайн ургамлан бүрхэвч, зүйлийн бүрдэл, суурийн судалгаа хийх	Төслийн талбайд	Шинээр байгуулах	Жилд 1-2 удаа	-	Байгалийн ургамлын тухай Монгол улсын хууль, ЭТТ ХК-ийн дотоод журмууд Өнгөн хөрстэй ажиллах журам, Ховор, нэн ховор ургамлыг хамгаалах журмууд
<b>5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>							
5.5.1	Машин механизм, хүний хөл хөдөлгөөн, дуу чимээнээс үүдэн амьтад амьдрах орчноосоо үргэх, түр хугацаанд амьдрах орчны хуваагдал үүсэх	Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, Шөнө оройн цагаар ажиллахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.	Төслийн талбайд	-	Жилд 1-2 удаа	4,000,000	Амьтны тухай хууль
5.5.2	Усны шугам хоолой болон барилга байгууламж барих явцад шавж, мэрэгч гэх мэт амьтдын төрөл зүйлийн амьдрах орчин өөрчлөгдөх	Үйл ажиллагаа явуулж буй газрын бүс нутгийн амьтдын хамгааллын талаар амьтны судалгаа хийнэ.	Төслийн талбайд	-	Жилд 2 удаа	5,800,000	Амьтны тухай хууль



## **5.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

### **5.1.1 Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах**

Барилгын ажлын үед ашиглагдах технолгийн замуудын нөхцлийг сайжруулах чиглэлээр шаардлагатай тохиолдолд усалгааг хийх, өвлийн улиралд тухайн нөхцөлд байдалд тохируулан зам талбайн усалгаа, арчилгааг тогтмол хийж гүйцэтгэнэ.

### **5.1.2 Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх**

Төслийн барилгын ажлын явцад ашиглах техникийн өдөр тутмын үзлэг шалгалтыг тогтмол хийнэ. Дуу шуугианы хэмжилтийг хагас жилд нэг удаа хийж гүйцэтгэж стандартаас давуулахгүй байх зорилгоор машин, техникийн засвар үйлчилгээг тухай бүрт нь тогтмол хийж гүйцэтгэнэ.

### **5.1.3 Бохирын цооногт септоник бодис хийж бактерийг устган, ялзруулж, саарал ус болсоны дараа гэрээт байгууллагад нийлүүлэх**

Загийн усны хоолой төслийн туслан гүйцэтгэгчээр шалгарсан 6-н байгууллагын ажилтнуудын амрах түр хотхоны цэвэрлэх байгууламжийн бохир ус хадгалах, цуглуулах септик системийн үйл ажиллагаанд байнгын хянат шалгалтыг хийж, септик системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор септоник бодис хийх замаар ялзралтыг түргэсгэх бодисыг тогтмол хугацаанд хийж бүртгэл хөтлөнө.

Саарал ус нийлүүлэх гэрээг тусгай өвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй байгуулан гэрээний дагуу нийлүүлнэ.

## **5.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

### **5.2.1 Ажилтны амрах хотхоны нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах**

Туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдын амрах хотхоны нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг хийж сар бүр ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэнэ.

### **5.2.2 Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх**

Ажилчдын амрах хотхонд хөрсний элэгдэл эвдрэл үүсгэхгүй байхад зориулан явган хүний замыг бий болгон зөвхөн тэр замаар зорчих боломжийг бүрдүүлнэ. Мөн хотхон дотор тохижилтийн ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

### **5.2.3 Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах**

Барилгын ажилд ашиглах материалыг зөвхөн зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс гэрээ байгуулсаны үндсэн дээр авч ашиглана. Уг ажилд захиалагч талын Байгаль орчны мэргэжилтэнүүд тогтмол хяналт хийж үл нийцэл, зөрчил гаргуулахгүй байхад анхаарна.

### **5.2.4 Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ны “Өнгөн хөрстэй ажиллах журам” ETT-SA-J14-BO-J09-H03-ын дагуу газар шорооны ажил эхлэх үед зөвшөөрлийг захиалагч талаас авч уг зөвшөөрөлд заасны дагуу өнгөн хөрсийг хуулж бусад шимэрхэг хөрстэй холихгүй тусад нь хадгалж ус дамжуулах сувгийн газар шорооны ажил дуусан үед буцаан булах ажлыг стандар болон дотоод журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

### **5.2.5 Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр поошгинд цуглуулах**

Машин техникүүдийг түлш, шатах тослох материалаар цэнэглэх болон засвар үйлчигээ хийх үед хөрсийг бохирдохоос сэргийлэхийн тулд тухайн талбайд асгаралтын иж бүрдлийг байрлуулж хөрс бохирдсон үед “Эрдэнэс Тавантолгой” ХК-ын “Асгаралтын журам”-ын адгуу хариу арга хэмжээг авч ажиллана.

### **5.2.6 Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих**

Шугам хоолойн газар шорооны ажил болон ажилчдын ирэх буцах, сумын төврүү зорчих зэрэг ажлуудаар зорчих үеийн автозамын маршрутыг гаргаж сумын холбогдох албан тушаалтнаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана. Маршрутын замаар зорчиж буй эсэхэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн мэргэжилтэнүүд байнгын хяналт тавьж ажиллана.

## **5.3 Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

### **5.3.1 Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх**

Ус цуглуулах 14 худгийг гүний усыг бохирдуулахгүй байхаар бүрэн тоноглоно. Мөн худгуудыг үерийн ус орохгүй байхаар худгийн шалыг өндөрлөх, ус дамжуулах суваг шуудуйг ус алдалгүй байхаар төлөвлөж, барилгын ажлын явцад байнгын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

### **5.3.2 Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах**

Монгол улсын “Усны тухай” хууль болон түүнийг дагалдан гарсан журам, зааврын дагуу Загийн усны хоолой төслийн 14 худгийн ус ашиглах боломжит нөөцийг дүгнэлтийг холбогдох хууль, дүрэм, зааврын дагуу “Монгол ус” ТӨҮГ-аар гаргуулан бичиг баримтыг бүрдлийг хангуулна.

### **5.3.3 Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах**

Төслийн талбай байрлаж буй малчны 2 ш худагт бага гүний усны түвшиний ажиглалтыг хийх зорилгоор автомат ажиллагаатай 24/7/365 тасралтгүй ажиллах чадвартай түвшин хэмжигч багаж байрлуулан сар бүр дата мэдээллийг цуглуулж усны түвшинд байнгын хяналт мониторингийг хийж гүйцэтгэнэ.

## **5.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

### **5.4.1 Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах**

Төслийн талбайд барилга байгууламж, зам, дэд бүтээн байгуулалтаас үүдэж ургамлан нөмрөг тоожилтонд дарагдаж, өсөлт, хөгжилд өөрчлөлт орох, ургамал давжаарах, хөрсний элэгдэл үүсэх магадлалтай учраас нөлөөллийн бүсэд ургадаг ургамлын ургалтыг 2023 оноос эхлэн хяналтын цэг байгуулж жил бүр 1 удаа мониторинг судалгааг хийнэ. Ургамал ургаж, боловсорч гүйцсэн үед 7,8 сардууд ургамлын мониторингийг хийхээр төлөвлөж байна. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон ургамлан нөмрөг доройтож буй эсэхэд байнгын хяналтыг хийнэ.

## **5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

### **5.5.1 Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах**

Төслийн талбайд байрлах ан амьтан ундаалдаг булаг, шандын байрлалын судалгаа хийж сум орон нутгийн зөвшөөрлийг авч хашиж, хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ. Хэрэв булаг, шанд байхгүй бол ус дамжуулах шугамаас услах арга хэмжээ авах судалгааг хийнэ.

**5.5.2 Үйл ажиллагаа явуулж буй газрын бүс нутгийн амьтдын хамгааллын талаар Мэргэжлийн судлаачаас зөвлөгөө авах, хамгаалах тал дээр ажиллах**

Төслийн талбайн хэмжээнд зэрлэг ан амьтан болон мөлхөгчийн судалгааг хавар, намрын улиралд зохион байгуулна. Хэрэв төслийн талбайд булаг шанд байгаа бол түүнд амьтны мониторинг хийх автомат камер байрлуулна.

## 6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, сая ₮	Эрх зүйн баримт бичиг
6.1.1	Газар шороо, барилгын ажлын үед эвдэрч талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлт хийх	Газар шорооны ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тухайн орчны газрын гадаргын төрх байдалтай уялдуулан хийх, орчны хог хаягдлыг цэвэрлэх	Шугам хоолойн трасс дагуу болон насос станц, худаг орчим	-	-	Төслийн хугацаанд	63,225,000	MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
6.1.2	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр	Төслийн талбай орчим	ш	1000	Төслийн хугацаанд	-	

### 6.1.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн талбайд төсөл хэрэгжүүлж эхлэхэд буую Усны эх үүсвэрээс худаг гаргах, Загийн уснаас шугам хоолой татах болон барилгын ажил хийх явцад хөрсөнд эвдрэл үүсэх ба газар шороо, барилгын ажил явагдаж дууссаны дараагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай юм.

Загийн усны шугам хоолой барих үйл ажиллагаанд ус цуглуулах болон дамжуулах салбар шугам, өргөлтийн насос станц, өргөлтийн насосын өмнөх усан сан, ус нөөцлөх талбайн хэмжээ нийт 40.4 га. Мөн овоолго шорооны хэмжээ 39 га бөгөөд нийт 79.5 га талбай эвдрэлд өртөнө. Үүнээс Загийн усны шугам хоолойн 96.3 км буюу 40.4 га талбай дахин нөхөн сэргэх боломжтой тул эвдэрсэн газар дээр тенхикийн болон биологийн нөхөн сэргээлт хийх бүрэн боломжтой юм.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу “MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага” стандартад нийцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

### 6.1.2 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-д нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 180 сая мод тарихаар төлөвлөсөн. Уг хөтөлбөрийн хүрээнд болон Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 04-р сарын 23-ны өдрийн 56 дугаартай тогтоолоор батлагдсан “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн үйл ажиллагаатай уялдуулан энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төлөвлөгөөт онд 1600 ширхэг мод бут тарихаар төлөвлөж байна.

## 7 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгааллын зардал нь дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгаа, дүйцүүлэн хамгаалах газрын менежментийн зардал, биологийн олон янз байдлын хамгааллын арга хэмжээ, гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал зэргээс бүрдэнэ.

Дүйцүүлэн хамгаалах газрын менежментийн зардал нь тухайн газар нутагт биологийн олон янз байдлын эерэг үр дүнд хүрэхэд шаардлагатай менежментийн зардлаас бүрдэнэ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төсөвт дараах зардлууд орно. Үүнд:

- Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгааны зардал ( $E_r$ ) нь тухайн төслийн нөлөөллийн эрчим, түүний хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар, түүний хэмжээг тогтоох зөвлөх үйлчилгээний зардлаас бүрдэнэ.
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх зардал ( $E_p$ ) нь биологийн олон янз байдлын суурь судалгааны зардал ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг талуудын оролцоотойгоор төлөвлөх, төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулах арга хэмжээний зардлууд орно.
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал ( $E_o$ ) нь тухайн газар нутагт хэрэгжүүлэх биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгжүүлэх шаардлагатай менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх зардлаас бүрдэнэ.

$$E_o = \{(C * R) * (1 + r)t\}$$

Үүнд:  $E_o$  – Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал

$S_o$ -Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай, шууд болон шууд бус нөлөөлөлд өртсөн талбайн хэмжээ (га)

$C$ -Дүйцүүлэн хамгаалах нэг га-д ногдох зардал,  $C=(5t.n)10$

$R$ -Дүйцүүлэн хамгааллын харьцааны итгэлцүүрийн утга  $R=10$

$(1+r)t$ -хэрэв дүйцүүлэн хамгааллын зардлыг нэгээс илүү жилээр төлөвлөх бол инфляц тооцно.

Гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал ( $E_m$ ) нь дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлаас бүрдэнэ. Иймд дүйцүүлэн хамгаалах зардлын нийт хэмжээг дараах байдлаар тооцно.

$$E_{total} = E_r + E_p + E_o + E_m$$

Үүнд:  $E_{total}$ –Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт зардал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр 2818 га газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай талаар тайлагнасан бөгөөд төлөвлөгөөт онд Өмнөговь аймгийн БОАЖГ болон Цогтцэций сумын ЗДТГ-аас санал авч дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршлыг тодорхойлно.

Тодорхойлсон байршилд биологийн олон янз байдлын суурь судалгаа болон дүйцүүлэн хамгааллын ажилд төлөвлөгөөт онд 84,173,660 төгрөг зарцуулахаар төлөвлөв.

## 8 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зарцуулах зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>8.1 Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>							
8.1.1	Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсад заавар зөвлөмж өгөх, мэдлэг ойлголт өгөх	Төслийн талбай	Удаа	2	200,000	Жилийн турш	MNS (ISO) 13688:2000 Хамгаалалтын хувцасны ерөнхий шаардлага
8.1.2	Осол эрсдэлд зориулалтын хэрэгсэл ашиглах	Төслийн талбайд	Багц	1	2,000,000	Жилд 1 удаа	
<b>8.2 Биологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>							
8.2.1	Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Төслийн талбай болон бүс нутаг	Багц	1	2,000,000	Жилийн турш	
<b>8.3 Технологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>							
8.3.1	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөний улмаас бие эрхтэнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах	Ажилчид	-	1	4,000,000	Жилийн турш	

## 9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт зардал, сая ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9.1.1	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн, хогийн цэгийг ариутгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	Кемп орчим	-	Төслийн хугацаанд	10,000,000	Хог хаягдлын тухай хууль "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"
9.1.2	Ахуйн	Хог хаягдал болон бохир ус тээвэрлүүлэх гэрээ байгуулах, гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хог хаягдлыг зайлуулах, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, бохир усыг зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх, дахин боловсруулах боломжтой хог аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зайлуулах	Кемпийн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдал	-	Төслийн хугацаанд	15,000,000	
9.1.3	Ахуйн	Ажилчдын сууцнаас салхин доор 50 м-ээс багагүй зайд хог хаягдлын зориулалтын түр цэг байгуулах /бороо цас, үерийн усанд автхааргүй, салхин шуурганд хийсхээргүй, хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай/	Ажилчдын түр кемп	-	Төслийн хугацаанд	5,000,000	
9.1.4	Ахуйн	Орчны эрүүл ахуйг ханган ажиллаж 14-30 хоногт 1 удаа нийтийг хамарсан цэвэрлэгээ хийх	Төслийн талбай болон нөлөөллийн бүс		Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	
9.1.5	Аюултай	Машин механизмын эвдрэл гэмтлээс үүдэн түлш, тос масло асгарч болзошгүй тул засвар үйлчилгээг тогтмол хийх, бохирдсон арчих материал, хаягдал сэлбэгийг тусгайлан бэлдсэн талбайд хураах /бетонон суурьтай талбай эсвэл пошиг, торхонд/	Туслан гүйцэтгэгч		Төслийн хугацаанд	16,930,000	



## 10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт № 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, ₮	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>10.1 Агаарын чанар</b>								
10.1.1	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Төслийн талбай Ажилтны амрах хотхон Хяналтын цэг: Грийн цэнтр	4 ба 8-р сард	2	80,000	480,000	-	Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. MNS 0017-2-3-16 : 1988 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага. MNS 3113 : 1981
10.1.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ		8-р сард	1	62,000	372,000	-	
10.1.3	Дуу чимээний хяналт		4 ба 8-р сард	2	80,000	480,000	-	
<b>10.2 Усны чанар</b>								
10.2.1	Усны хими, физизийн ерөнхий шинжилгээ	14 худаг	4 ба 8-р сард	2	37,500	1,050,000	-	Ундны усны эсвэл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 900:2010 Усны чанар. Усны дээжлэлт. Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэх уснаас дээж авах хөтөлбөр боловсруулах. MNS5667-5:2001.
10.2.2	Худгуудын усны бактериологийн шинжилгээ	14 худаг	4 ба 8-р сард	2	58,000	1,624,000	-	
<b>10.3 Хөрсөн бүрхэвч</b>								
10.3.1	Хөрсний агрохимийн үзүүлэлт	5 цэгээс	4 ба 8-р сард	2	25,000	250,000	-	Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS 3298 – 90

10.3.2	Ерөнхий хими, физик	5 цэгээс	4 ба 8-р сард	2	25,000	250,000	-	
10.3.3	Хөрсөн дэхь хүнд метал	3 цэгээс	8 сард	1	30,000	300,000	-	
<b>10.4 Ургамлан нөмрөг</b>								
10.4.1	Ургамлын мониторинг, бичиглэл	3 цэгт	4 ба 8-р сард	2	-	-	-	Байгалийн ургамлын тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль MNS5918:2008
<b>10.5 Амьтны аймаг</b>								
10.5.1	Амьтны мониторинг судалгаа	3 байрлалд	4 ба 8-р сард	2	-	-	-	Амьтны тухай хууль

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав.

Хүснэгт № 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
11.1	Байгаль орчны аудит хийлгэх.	Төслийн хэмжээгээр	1,400,000	Тухайн жилд	БОАМ, БОМ нар

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
11.2	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах	2023 оны БОМТ	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн 11-12 дугаар сард	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
11.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	2023 оны БОМТ	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн эхний улиралд багтаан	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
11.4	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	2023 оны БОМТ-ний биелэлтийн тайлан	Үйл ажиллагааны зардал	Тухайн жилийн 12-р сард багтаан	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж

**12 НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт № 12. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

Бүлэг	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Нийт зардал, сая ₮	Хариуцах ажилтан	Зохион байгуулах газар
12.1	Багийн иргэд	Танхим	БОМТ тайлагнах	12-р сар	500,000	Холбогдох хэлтэс нэгж, туслан гүйцэтгэгч нар	Цогтцэций сумын соёлын төв
12.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэн	Уулзалт, ярилцлага	Үйл ажиллагааг танилцуулах	Жилд 2 удаа	1,300,000	Холбогдох хэлтэс нэгж, туслан гүйцэтгэгч нар	Цогтцэций сумын соёлын төв

### 13 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Хүснэгт № 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	БОМТ ангилал	Төсөв, мян₮
1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	45,280,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	63,225,000
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	84,173,660
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	8,200,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	46,930,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,806,000
7	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	1,400,000
8	Оршин суугч, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	1,800,000
<b>Нийт</b>		<b>255,814,660</b>

### 14 ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР

Тухайн ажилд шаардагдах хөрөнгө зардал, нөөц, цаг хугацаа, сөрөг нөлөөллийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан ач холбогдолын эрэмбэ зохиож эзлэх жинг тодорхойлсон болно.

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур	Эзлэх жин
<b>5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>				
5.1.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Зам талбайг усалж тоосжилтыг дарах	Тоосны түвшинг хамгийн бага байлгах түвшинд усалгааг хийнэ.	2
5.1.2		Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх	Дуу шуугианы хэмжилтийг жилд 2-оос багагүй хийж 5-аас багагүй техникт засвар үйлчилгээ хийсэн байна.	1
5.1.3		Түр ашиглах ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааг хангах	Туслан гүйцэтгэгч компани бүрийн ажилтны хотхонд түр ашиглах боловсон ариун цэврийн байгууламж байрлуулсан байна.	2
5.2.1	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Нянгийн бохирдлоор хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх	3-аас багагүй нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэлийг байнга авч хэрэгжүүлнэ.	1
5.2.2		Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх	3-н ажилтны хотхонд явган хүний ам талбайг хийж тохижуулна.	1
5.2.3		Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах	Бетон нийлүүлэх байгуулагуудтай гэрээ байгуулсан байна.	0,5
5.2.4		Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх.	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимтэй хөрс хуулалт, хадгалалт стандартын шаардлагыг бүрэн хангана.	0,5

5.2.5		Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр пошгинд цуглуулах	Зөрчилгүй ажилласан байна.	0,5
5.2.6		Ажилчдын кемп байгуулахын өмнө сумаас зөвшөөрөл авах, гэрээ байгуулах, ЭТТ ХК-ийн БОУБХ-т холбогдох зөвшөөрөл, гэрээ, бусад баримт бичгийг ирүүлэх	Газрын зөвшөөрөл, гэрээг бүрэн хангаж бичиг баримтын бүрдлийг 100 хувь хангасан байна.	0,5
5.2.7		Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих	Замын маршрутыг сумын Цагдаагийн газраар батлуулж мөрдөж ажиллана.	1
5.3.1		Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах.	Зөрчил гаргахгүй ажиллах	1
5.3.2	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	Бүх худгуудад боломжит нөөцийн дүгнэлт гаргуулна.	2
5.3.3		Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах	2 малчны худагт автомат түвшин хэмжигч бага суурилуулна. Хэрэв худалдан ваалт хийгдэхгүй бол гар түвшин хэмжигчээр сар бүр хэмжинэ.	2
5.4.1		Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах	2-оос доошгүй удаа нийт ажилтнуудад сургалт орно.	3
5.5.1	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах, Шөнө оройн цагаар ажиллахгүй байх	Шөнө оройн цагаар хүнд машин механизм ажиллуулахгүй байна.	1
5.5.2		Амьтны мониторинг судалгаа хийх	Жилдээ 2 удаа амьтны мониторинг хийнэ	1
				<b>20</b>
<b>6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</b>				
6.1.1	Газар шороо, барилгын ажлын үед эвдэрч талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлт хийх	Газар шорооны ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тухайн орчны газрын гадаргын төрх байдалтай уялдуулан хийх, орчны хог хаягдлыг цэвэрлэх	Шугам хоолойн ажил бүрэн дууссаны дараа ухлагт ашигласан материалыг бүрэн буцаан хийж нөхөн сэргээлтийг 100 хувь хийж гүйцэтгэнэ.	15
6.1.2	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр	1000 ширхэг мод тарьна.	15
				<b>30</b>
<b>7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</b>				
7.1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил	Дүйцүүлэн хамгаалал хийх газар нутгийг сонгох	Аймгийн БОАЖГ болон Сумын ЗДТГ-аас санал авч газар нутгийг тогтоосон байна.	5

7.2		Сонгогдсон газарт суурь судалгаа хийх.	Сонгогдсон нутагт уст цэг, амьтан, ургамлын суурь судалгааг хийсэн байна.	5
				<b>10</b>
<b>8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</b>				
8.1.1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсдад заавар зөвлөмж өгөх, мэдлэг ойлголт хийх	2-ээс доошгүй удаа сургалт, зааварчилгаа өгсөн байна.	1
8.1.2		Осол эрсдэлд зориулалтын хэрэгсэл ашиглах	Галын аюулын багаж хэрэгслийг хангалттай хэмжээгээр байршуулна.	2
8.2.1	Биологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Цар тахлын үеийн аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллана.	2
8.3.1	Технологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөний улмаас бие эрхтэнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах, эрсдлийн санг бий болгох	Ажлын аюулгүй ажиллагааны дүрэм, горим, заавар боловсруулж үйл ажиллагаандаа мөрүүлж ажиллана.	5
				<b>10</b>
<b>9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө</b>				
9.1.1		Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн, хогийн цэгийг ариутгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	Хогийн цэгийн ариутгал хадвтаргүйгэлийг 7 хоног бүр хийнэ.	2
9.1.2	Ахуйн хог хаягдал	Хог хаягдал болон бохир ус тээвэрлүүлэх гэрээ байгуулах, гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хог хаягдлыг зайлуулах, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, бохир усыг зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх, дахин боловсруулах боломжтой хог аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ	Сумын эрх бүхий хог хаягдал хүлээн авах, тээвэрлэх байгууллагатай гэрээ хийж, гэрээний үндсэн дээр нийлүүлж төлбөрийг тухай бүрт төлнө.	2



		байгуулж, гэрээний дагуу зайлуулах		
9.1.3		Ажилчдын сууцнаас салхин доор 50 м-ээс багагүй зайд хог хаягдлын зориулалтын түр цэг байгуулах /бороо цас, үерийн усанд автхааргүй, салхин шуурганд хийсхээргүй, хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай/	Хог хаягдлын түр хогийн цэгийг стандартын дагуу байгуулна.	2
9.1.4		Орчны эрүүл ахуйг ханган ажиллаж 14-30 хоногт 1 удаа нийтийг хамарсан цэвэрлэгээ хийх	Бүх нийтийн их цэвэрлэгээг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэнэ.	2
9.1.5	Аюултай хог хаягдал	Машин механизмын эвдрэл гэмтлээс үүдэн түлш, тос масло асгарч болзошгүй тул засвар үйлчилгээг тогтмол хийх, бохирдсон арчих материал, хаягдал сэлбэгийг тусгайлан бэлдсэн талбайд хураах /бетонон суурьтай талбай эсвэл поошиг, торхонд/	Засварын түр талбайг хөрсөнд нөлөөлөл үзүүлэхгүй байхаар зохион байгуулж хийнэ.	2
				<b>10</b>
<b>10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр</b>				
10.1.1	Агаарын чанар	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Жилийн турш 50 цаг/жил хүчинтэй хэмжилтийг хийж гүйцэтгэсэн байна.	1
10.1.2		Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Жилд 1 удаа буюу намрын улиралд хэмжилт хийсэн байна.	1
10.1.3		Дуу чимээний хяналт	Жилд 2 удаа буюу намар, өвлийн улиралд хэмжилт хийсэн байна.	1
10.2.1	Усны чанар	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	14 худагт жилд 2 удаа шинжилгээ хийлгэсэн байна.	1
10.2.2		Худгуудын усны бактериологийн шинжилгээ	14 худагт жилд 2 удаа шинжилгээ хийлгэсэн байна.	1
10.3.1	Хөрсөн бүрхэвч	Хөрсний агрохимийн үзүүлэлт	5 цэгээс жилд 2 удаа	1
10.3.2		Ерөнхий хими, физик	5 цэгээс жилд 2 удаа	1
10.3.3		Хөрсөн дэхь хүнд метал	3 цэгээс жилд 1 удаа	1
10.4.1	Ургамлан нөмрөг	Ургамлын мониторинг	Жилд 2 удаа 3 цэгт хийнэ.	1
10.5.1	Амьтны аймаг	Амьтны мониторинг	Жилд 2 удаа 3 байрлалд хийнэ.	1
				<b>10</b>
<b>11. Удрдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө</b>				
11.1	Байгаль орчны аудит хийлгэх.		Аудитын тайлангаар	2
11.2	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах		БОМТ-ний барьцаа хөрөнгийг 100 хувь байршуулсан байна.	1
11.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны		БОМТ-г БОАЖЯ-аар батлуулсан байна.	1

	асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах		
11.4	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	БОМТ-ийн биелэлтийн тайланг Өмнөговь аймгийн БОАЖГ-аар батлуулсан байна.	1
			<b>5</b>
<b>12. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө</b>			
12.1	Багийн иргэд	Багийн иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнасан байна.	2.5
12.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэн	Төслийн үйл ажиллагааны талаар нөлөөллийн бүсийн иргэдэд танилцуулсан байна.	2.5
			<b>5</b>
			<b>100</b>